



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№87 /531/

2023.05.29

Цаг үе, үйл явдал

ЦЭНХЭР ДУУЛГАТ ДАЙЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Олон Улсын Энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх “Монгол цэрэг-Энхийн төлөө” дурсгалын цогцолборт Монгол Улсын Зэвсэгт хүчин, төрийн цэргийн байгууллагуудаас энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэнхэр дуулгат дайчдад хүндэтгэл үзүүлээ. Энэ үеэр “Монгол дайчин-Mongol Warrior” энх тайвны төлөөх бүх нийтийн гүйлтийн тэмцээн явагдаж, дурсгалын цогцолборт цэцэг өргөж, мод тарьсан юм.

Тусарга хэмжээнд УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Н.Энхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, гадаад бодлогын зөвлөх дэслэгч генерал Ц.Тогоо, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба болон БХЯ, ЗХЖШ-ын үеийн удирдлагууд оролцов.

Хүндэтгэлийн арга хэмжээний үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хэлсэн

үгэндээ, “Батлан хамгаалах яам, удирдлагын хувьд салбарын хууль тогтоомжийг үе шаттайгаар шинэчлэх, богино, дунд, урт хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны оролцоо, боломжийг нэмэгдүүлэх, цаашид удирдах албан тушаалтны тоог ахиулах, “Мотоуудлагын батальон”, “Түргэн байрлах хүчний рот”, “Инженерийн рот”, “Цэргийн хээрийн хоёрдугаар шатны эмнэлэг”-ийг оролцуулах, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” тогтоолын дагуу энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын тоог үе шаттай нэмэгдүүлж, улмаар 15 хувьд хүргэх зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн Батлан хамгаалахын сайдын тушаалаар 2022 онд ТАБНУ, Бүгд Найрамдах Мали Улсад явагдаж буй ажиллагаанд штабын

ажилтан, цэргийн мэргэжилтнүүдийг, 2023 оны 05 дугаар сараас Бүгд Найрамдах Ливан Улсад явагдаж буй ажиллагаанд “Олон улсын I шатны эмнэлгийн баг”-т эмнэлгийн мэргэжилтнүүдийг анхлан үүрэг гүйцэтгүүлэхээр ажиллагааны газар оронд илгээгээд байна.

Тэртээ 21 жилийн өмнө холыг харж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг илгээх шийдвэр гаргахад онцгой үүрэг гүйцэтгэсэн эрхмүүд, түүний залгамжийг үргэлжлүүлэн авч яваа Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлага, хамт олон, энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн, одоо үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа нийт энхийг сахиулагчдадаа талархал илэрхийлж, “Олон Улсын Энхийг сахиулагчдын өдөр”-ийн мэндийг дахин дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе” гэв.

“БУЯНТ-УХАА ЭЙР ШОУ 2023”...



зэрэгцээ хорьдугаар зуунд авиакompани болон Батлан сансрын уудамд хүнээ нисгэсэн Ази тивийн анхдагч улс болж эгнээнээсээ Улсын баатар тав, Монгол Улсын гавьяат цолтон 30 гаруйг төрүүлсэн бахдам амжилтыг энэ мөчид тэмдэглэн хэллэхэд бахархалтай байна” хэмээсэн юм.

“Агаарын шоу”-ны үеэр орчин үеийн дуунаас хурдан сөнөөгч онгоцны нислэг, нисдэг тэрэг, бага оврын ачааны хөлгийн үзүүлэх тоглолтууд, шүхэрчдийнд буулт, авьяаслаг хүүхэд, багачуудын нисэх загварын үзүүлбэр, гэр бүл хүүхэд залууст зориулсан хамтлаг, дуучдын тоглолтууд үзэгч олны хүртээл боллоо.

Тус арга хэмжээг МИАТ, ИНЕГ, Төрийн өмчит болон хувийн хэвшлийн 14

авиакompани болон Батлан хамгаалах яам, Зам, тээврийн хөгжлийн яам, БОАЖЯ, ЗХЖШ, Агаарын цэргийн командлал, түүний харьяа анги байгууллагууд, НЗДТГ, ОБЕГ хамтран зохион байгуулсан юм.



Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 98 жил, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал байгуулагдсаны 66 жилийн ойг тохиолдуулан “Буянт-Ухаа Эйр шоу 2023” арга хэмжээг зохион байгууллаа.

“Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал нь 2021 оноос эхлэн нисэхийн салбар, ерөнхий зориулалтын болон улсын нисэх үйл ажиллагааг нийтэд сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор уг арга хэмжээний цар хүрээ, үзэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн агаарын хөлгийн парад, үзүүлэх тоглолт, уралдаан тэмцээн, хөгжмийн фестивалиар хөтөлбөрийг баяжуулан гурав дахь жилдээ амжилттай зохион байгуулсан юм.

Арга хэмжээг нээж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хэлсэн үгэндээ “Монгол Улсын Нисэх хүчний түүх Монгол цэргийн нисэх хүчний түүхээс эхлэлтэй. Тухайлбал, 1990 оныг хүртэл иргэний нисэхийн үйлчилгээг тангараг өргөсөн цэргийн алба хаагчид гүйцэтгэж байсан түүхтэй. Эл түүхийн он жилүүдэд Монгол залуус цэргийн болон иргэний зориулалтын нисэх онгоц, техникийг гарамгай эзэмшиж, улс орныхоо агаарын тээврийн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан төдийгүй 1939 оны “Халхын голын байлдаан”, 1945 оны “Чөлөөлөх дайн”, 1940-1948 оны “Баруун хилийн тулгаралт”-д оролцож түүхэн баатарлаг гавьяа байгуулсны



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 8

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	🌧️ 29

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,445	3,460
EUR 🇪🇺	3,778	3,801
CNY 🇨🇳	498	501
RUB 🇷🇺	43	43.90
JPY 🇯🇵	26	26,10
KRW 🇰🇷	2.59	2.62


ЗУРХАЙ



2023.05.29 /ДАВАА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 9

**ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН
МОГОЙ САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
УЛААГЧИН ГАХАЙ ӨДӨР**

Үс засуулбал:
Өвчин өчүүхэн ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.00-20.39
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Мунхрахуй



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 688,379,964

Эдгэрсэн

Нийт: 660,813,344

Нас барсан

Нийт: 6,874,902

Цахим шууданд

БАЙГУУЛЛАГЫН ДҮНГЭЭР ХИЛЧИН ДАЙЧИД, ХУВИЙН ТӨРӨЛД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЦЭРГҮҮД ӨНГӨЛЛӨӨ



Эрдэнэ, Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн дэд түрүүч Б.Бүдбаатар нарын энгэрт "Онц сурлагатан" медаль гялалзаж, мэргэн буудагчид болох Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн дэд түрүүч Ц.Төгөлдөр, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн дэд түрүүч Б.Батзориг, Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн байлдагч Н.Баяржаргал нар "Онц буудагч"-аар өргөмжлөгдлөө.

Харин "Тамирчин дайчин" медалийг хурд хүч, тэсвэр хатуужлаараа бусдаасаа илт давуу шалгарсан Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн дэд түрүүч Б.Анарзаяа, Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн байлдагч Э.Тэмүүлэн, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн дэд түрүүч Э.Мөнгөнхөлөг нар хүртэж, дайчин нөхдийнхөө алга ташилтаар шагнагдав.

Тэмцээнд оролцогчдод Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал хандаж хэлэхдээ мөр зэрэгцэн хугацаат цэргийн алба хааж байгаа нөхдөөсөө шалгаран оролцож, бүр шилдгийн шилдэг болж чадсан эрхэм түрүүч, байлдагч нартаа баяр хүргэв. Тэмцээнд амжилт үзүүлсэн, эс үзүүлснээс үл хамааран бүх хугацаат цэргийн алба хаагч бол бидний бахархал хэмээн онцлоод баг тамирчдаа өндөр хэмжээнд бэлтгэн оролцуулсан нэгтгэл, ангийн удирдлагуудад талархал илэрхийлсэн юм.

ХИЛЧИН ДАЙЧИД ОНЦГОЙ АЧ ХОЛБОГДОЛ ӨГЧ ОРОЛЦОО

Энэ үеэр ХХЕГ-ын Цэргийн албаны зохион байгуулалтын газрын дарга, хурандаа Ц.Батбаатарын сэтгэгдлийг хуваалцлаа.

"Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал энэ тэмцээний ач холбогдолыг маш тодорхой хэллээ. Цэргийн албанаас авсан тэсвэр хатуужил, эр зориг, төлөвлөлт зохион байгуулалт, эмх цэгц таны амьдралд насан туршид хэрэг болох чанар гэж. Үнэхээр л улс орны ирээдүйн эздийг ёс зүйт иргэн, цэрэг-эх оронч үзэл хүмүүжилтэй болгон төлөвшүүлэхэд хугацаат цэргийн алба онцгой үүрэгтэй. Хоёрдугаарт Хил хамгаалах байгууллагаас энэхүү тэмцээнд онцгой ач холбогдол өгч оролцлоо. Хилчин дайчнаа төлөөлж оролцох түрүүч, байлдагч нарынхаа дунд нэгдсэн тэмцээн зохион байгуулж, шалгарсан хугацаат цэргийн алба хаагчдаа оролцуулсан. Оролцсон дайчид маань ч цомын эзэд болж чадлаа. Маш их баяртай байна. 2023 он бол Хил хамгаалах байгууллагын хувьд онцгой жил. Хилийн хамгаалах байгууллагын түүхт 90 жил, Баруун хилийн зэвсэгт тулгаралт дууссаны 75 жил, Хилийн цэргийн 8 ангийн 90 жилийн ой тус тус тохиож байна. Түүхт ойгоо угтаж, олон ажил төлөвлөн хэрэгжүүлж байгаагийн нэг нь "Хилчдийн спортын жил"-ийг тохиолдуулсан арга хэмжээ юм.

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас төрийн цэргийн байгууллагуудын хугацаат цэргийн алба хаагчдын дунд "Цэргийн мэргэжлийн аварга түрүүч, байлдагч" шалгаруулах тэмцээнийг 5 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж явууллаа.

Тэмцээний хаалтын ёслолд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал, БХЯ-ны ГХАГ-ын ахлах мэргэжилтэн хурандаа С.Амарсайхан, ХХЕГ-ын Цэргийн албаны зохион байгуулалтын газрын дарга, хурандаа Ц.Батбаатар, Хуурай замын цэргийн ахлагчийг түр орлон гүйцэтгэгч, "Ахлагчийн хөгжлийн төв"-ийн дарга, сургагч ахлагч А.Баяртогтох, ХЗЦК-ын Сургалт бэлтгэлийн хэлтсийн дарга хурандаа Т.Тогмиддүүмий, Дотоодын цэргийн штабын Захиргааны удирдлагын газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга дэд хурандаа Ж.Батмөнх нарын удирдлагууд оролцож, аваргуудын шагналыг гардуулан өгч, баяр хүргэв.

Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргийн 30 гаруй нэгтгэл, ангийн 60 гаруй шилдэг хугацаат цэргийн алба хаагчид цэргийн хэргийн мэдлэг, бие бялдрын бэлтгэлжилт, тэсвэр хатуужлаараа өрсөлдсөнөөс "Цэргийн мэргэжлийн аварга

түрүүч"-ийн тэргүүн байрт Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн дэд түрүүч Б.Оюунбаатар, дэд байрт Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн дэд түрүүч Н.Цэрэнтогтох, гутгаар байрт Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн дэд түрүүч Б.Дарханбаяр нар шалгарлаа.

"Цэргийн мэргэжлийн аварга байлдагч"-ийн тэргүүн байрт Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн байлдагч Ц.Ариунбуян, дэд байрт Хилийн цэргийн 0277 дугаар ангийн байлдагч Н.Батзаяа, гутгаар байрт Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн байлдагч Г.Баттулга нар шалгарч, мөрдэс нэгт нөхдийнхөө өмнө бахархалтайгаар шагнагдлаа.

Ийнхүү байгууллагын нийлбэр дүнгээр шилжин явах цомын эзэнээр дэд хурандаа Э.Майдар захирагчтай Хилийн цэргийн 0214 дүгээр ангийнхан тодорч, дэд байрт хурандаа Н.Гүрбадам захирагчтай Зэвсэгт хүчний 256 дугаар анги, гутгаар байрт хурандаа Ц.Амарсайхан захирагчтай Зэвсэгт хүчний 110 дугаар ангийнхан шалгарлаа.

Мөн тэмцээний үеийн зарим даалгавар гүйцэтгэлтэд бусдыгаа тэргүүлсэн түрүүч, байлдагч нарт "Онц сурлагатан", "Тамирчин дайчин", "Онц буудагч" медалийг олгогдсоныг гардуулав. Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн байлдагч Х.Дашхүү, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн дэд түрүүч Э.Ган-

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗАЛУУ ОФИЦЕРУУД ЯВГАН АЯЛАЛД ОРОЛЦОЖ БАЙНА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулагдах "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын чуулган"-ыг угтан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд энэ сарын 26-ны өдөр Дотоодын цэргийн байгууллагаас төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудын дунд зохион байгуулагдаж байгаа "Эрүүл бие-Зөв дадал" сэдэвт явган аялалд ЗХЖШ болон Төрлийн цэргийн командлалын залуу офицерууд оролцож байна.

Уг арга хэмжээний нээлт "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" дэхь Дотоодын цэргийн хүндэтгэлийн цогцолборт болж, нээлтийн ажиллагаанд ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах оролцлоо.

"Эрүүл бие-Зөв дадал" сэдэвт явган аялал нь Төв аймгийн Манзшур хийдээс Богдхан уулын Цэцэг гүний ноён оргил чиглэлд 16.2 километр замыг туулж, нийт 10 байгууллагын төлөөлөл болсон залуу офицерууд хамрагдаж байна.

Дэд хурандаа А.БАТСҮХ

ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧДАД ЭНХИЙН ҮЙЛСИЙГ СУРТАЛЧЛАВ



Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн офицер, ахлагч нар Засгийн газрын 2012 оны 14 дүгээр тогтоолын дагуу жил бүрийн 05 дугаар сарын 29-ний өдрийг "Олон улсын энхийг сахиулагчдын өдөр" болгон тэмдэглэж ирснийг тохиолдуулан хугацаат цэргийн алба хаагчдад энхийг сахиулагчдынхаа амжилт, ололт, гавьяаг алдаршуулах зорилгоор энхийг дэмжих

ажиллагааны үүрэг, оролцоо, ач холбогдлын талаар "Монгол цэрэг энхийн үйлсэд-21" өдөрлөгийг зохион байгууллаа.

Энэ үеэр энхийг сахиулах ажиллагааны газар, орноос авч ирсэн дурсгалын зүйлсээр дайчдын дунд азын сугалаа, "Монгол цэрэг энхийн үйлсэд-21" гар зургийн уралдаан явуулж, шалгарсан дайчдад гарын бэлэг гардуулан өглөө.

Ахмад А.АЛТАНХУЯГ

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТООЛЛОГО, ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН ҮЗЛЭГЭЭР...



Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2023 оны А/203 дугаар "Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын улсын үзлэг, шалгалт явуулах тухай" тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба, Нийслэлийн тээврийн үйлчилгээний газрын Техникийн үзлэгийн төвтэй хамтран Батлан хамгаалахын салбар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, нэгжийн үндсэн хөрөнгө, данс бүртгэлд бүртгэлтэй тээврийн бүлгийн автомашин, чиргүүл, механизм, мотоциклийг техникийн үзлэг тооллогод хамруулах ажлыг энэ оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 90 хоногийн хугацаатай зохион байгуулж Зэвсэгт хүчний 310 дугаар ангиас эхлэж байна.

Үзлэгээр:

- Тухайн нэгтгэл, анги, байгууллага, салбарын үндсэн хөрөнгө данс бүртгэлд бүртгэлтэй

байгаа тээврийн бүлгийн автомашин, чиргүүл, механизм, мотоциклийн судалгааг, тээврийн бүлгийн жолооч нарын судалгааг гарган мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, "Авто тээврийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Замын хөдөлгөөний дүрэм, стандарт, журмын дагуу тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж техникийн хяналтын үзлэгт бэлтгэсэн байх, "Нийслэлийн тээврийн үйлчилгээний газрын Техникийн үзлэгийн төвийн явуулын оношилгооны автомашин хариуцсан инженер, техникийн ажилтанг оношилгооны багаж, тоног төхөөрөмжөөр явуулна. БХЯ-ны харьяа нэгжүүд, ЗХ-ний нэгтгэл, анги салбарын жолооч албан тушаалтай алба хаагч, ажилтанд "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль", "Замын хөдөлгөөний дүрэм", Зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх

талаар сургалтыг зохион байгуулна,

- Тухайн анги байгууллагын жолооч, алба хаагч, ажилтангаас Замын хөдөлгөөний дүрмийн тестээр мэдлэгийн түвшин тогтооно,
- Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар бэлэн бус торгуулийн шийтгэл оногдуулсан төлбөрийг бүрэн төлүүлэх ажлыг зохион байгуулах,
- Шалгалтад тэнцээгүй зөрчилтэй автомашин, механизм, мотоцикл, чиргүүлийн мэдээллийг нэгтгэн, зөрчлийг арилгуулах, давтан үзлэг тооллогод хамруулах талаар хугацаатай үүрэг, ажлын чиглэл, мэдэгдэл хүргүүлж заасан хугацаанд хариуг авч танилцуулахаар төлөвлөд байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБА

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 303 ДУГААР АНГИ "ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТ НЭГДЛЭЭ



Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн бие бүрэлдэхүүн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд ангийн байрлалд нийт 430 ширхэг бургас модны суулгацыг мод тарих үндэсний өдрөөр тарьж, суулгажээ.

Тус ажлыг зохион байгуулснаар хүрээлэн буй орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар хөрсний доройтлыг бууруулах, нөхөн сэргээх, агаарын бохирдлыг багасгах, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалахад чухал ач холбогдолтой юм.



* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)